




СҮРЬЕЭ ӨВЧИН ГЭЖ ЮУ ВЭ?

(Багш нарт зориулав.)

Сүрьеэ нь сүрьеэгийн савханцар хэмээх нянгаар үүсгэгддэг, хүнээс хүнд амьсгалын замаар дамжин халдварладаг нийгмийн халдвартай өвчин юм.

Уг өвчнийг үүсгэдэг нян нь гадна орчинд тэсвэртэй учраас нийгэмд их хор хөнөөлтэй гэж судлаачид үздэг.





СҮРЬЕЭГИЙН ХАЛДВАР ЯАЖ ТАРХДАГ ВЭ?

Сүрьеэгийн эх уурхай нь уушигны сүрьеэтэй өвчтөн юм. Уушигны халдвартай сүрьеэгээр өвдсөн хүн цаашаа 15-20 хүнд халдвар тараадаг гэж үздэг.

- Сүрьеэ өвчтэй хүнтэй хамт, агааржилт муутай байранд амьдрах, биеийн дархлаа суларсан зэргээс анхдагч голомт идэвхжинэ.

Сүрьеэтэй өвчтөний

ярих, ханиах, найтаах
үед олон сая сүрьеэгийн
савханцар агуулсан
дуслууд агаарт цацагдаж
улмаар бусдад агаар
дуслаар халдвар
дамждаг.



СҮРЬЕЭГИЙН НЯН НЬ

ТООСОНД

100 ХОНОГ

ХӨРСӨНД

6 САР

УСАНД

150 ХОНОГ

БУЦАЛГАХАД

10 МИНУТ

ЧИЙГЛЭГ

75°C ХЭМД


АМЬДРАХ ЧАДВАРТАЙ

УДААН ХУГАЦААНД ХУВААГДАН ҮРЖДЭГ
(20-24 ЦАГТ НЭГ УДАА) ОНЦЛОГТОЙ

НАРНЫ ШУУД ГЭРЭЛ БОЛОН **1** ЦАГИЙН ДОТОР
ХЭТ ЯГААН ТУЯАНД УСТДАГ



СҮРЬЕЭГЭЭР ХЭН Ч ӨВДӨХ ЭРСДЭЛТЭЙ ...



Манай улсад амьсгалын замын халдварт өвчний 40 гаруй хувийг сүрьеэ эзэлж байгаа бөгөөд хүн амын нас баралтын шалтгааны зургаадугаарт, тэр дотроо халдварт өвчний шалтгаантай нас баралтын нэгдүгээрт бичигддэг.

Өвчлөгсдийн 60 хувь нь ярих, ханиах, найтаахад агаараар дамжин нэгээс нөгөөд **халдварлах эрсдэл** дагуулдаг.

СҮРЬЕЭ ӨВЧНИЙ БАЙДАЛ

Дэлхийд

жил бүр **10.4** сая шинэ тохиолдол бүртгэгдэж,



1.8 сая хүн уг өвчний улмаас нас бардаг.

1.000.000

Хүүхэд сүрьеэгээр өвчилж,

200.000

Хүүхэд эндэж байна.

Монгол улс

сүрьеэгийн өвчлөл өндөртэй 37 орны 4-т ордог.



Жил бүр


4.000

гаруй хүн шинээр сүрьеэ өвчнөөр өвчилж байна.

УУШИГНЫ СҮРЬЕЭГИЙН ҮЕД ЯМАР ШИНЖ ИЛРЭХ ВЭ?

Өвчний эхлэл ихэнх тохиолдолд аажим явагдаж, хэдэн долоо хоног үргэлжилнэ. Хоёр долоо хоногоос дээш хугацаагаар ханиалгаж байгаа хүнийг сүрьеэгийн сэжигтэй гэж тооцно.

ЭДГЭЭР ШИНЖ ТЭМДЭГ ИЛЭРВЭЛ СҮРЬЕЭГИЙН ЭМЧИД ҮЗҮҮЛЭХ



СҮРЬЕЭ ӨВЧИН

- Сүрьеэгийн шинж тэмдэг илэрнэ.
- Бусдад халдвар тараана.
- Эрхтэн систем гэмтээнэ.
- Рентген болон цэрний шинжилгээнд өөрчлөлт илэрнэ.



Сүрьеэ өвчин бүрэн эдгэрдэг,
сүрьеэгийн эмчилгээ нь богино хугацаанд шууд
хяналттай хийгдэх ёстой бөгөөд **таны уйгагүй,
ухамсартай эм уултаас л шалтгаална.**

Эмчилгээний зарчим баримталснаар

- Өвчтөн төгс эмчлэгдэнэ
- Гэр бүлийнхэндээ болон ойр орчимдоо халдвар тараахгүй
- Хүндрэл буурна
- Эмийн дасал үүсгэхгүй зэрэг ач холбогдолтой.

СҮРЬЕЭ ӨВЧНӨӨС ХЭРХЭН СЭРГИЙЛЖ ЧАДАХ ВЭ?

Сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх арга

1.



Сүрьеэгээс урьдчилан сэргийлэх хамгийн эхний үр дүнтэй арга нь **БЦЖ** вакцин юм. **БЦЖ** вакциныг анх төрсөн, эрүүл гүйцэд нярайд 24 цагийн дотор 1 удаа тарьж дархлаажуулна.

2.



Өрөө тасалгаагаа байнга агууржуулж нар салхи оруулах, чийгтэй цэвэрлэгээг тогтмол хийж байх нь чухал.


Нарны туяа сүрьеэгийн нянг хурдан устгадаг.

3.




Сүрьеэгээр өвчлөхөөс сэргийлэх арга нь биеийн эсэргүүцлийг сайжруулах Үүнд: Хувь хүн өөрийн дархлаагаа сайжруулахын тулд чанарлаг хоол хүнсээр хооллох, биеийн тамир хөдөлгөөнийг эрхэмлэх, ажил амралтын дэглэм зөв тохируулж амрах, хорт зуршил хэрэглэхгүй байх явдал.


СҮРЬЕЭГ ДАРААХ ШИНЖИЛГЭЭГЭЭР ИЛРҮҮЛДЭГ



1. Цээжний
рентген зураг



2. Арьсны сорил




3. Цэрний шинжилгээ

Сүрьеэтэй өвчтөн:



Эмчилгээгээ бүрэн
төгс хийлгэх



Ханиаж найтахдаа
ам хамраа дарах,
амны хаалт зүүх



Гэр бүлийн
гишүүдээ урьдчилан
сэргийлэх үзлэгт
хамруулах



Дархлаагаа сайн байлгахын тулд:

- Тэжээллэг хоол хүнс хэрэглэх
- Ажил, амралтаа зохицуулж, ядрахгүй байх

СҮРЬЕЭТЭЙ ТЭМЦЭХ ДЭЛХИЙН ӨДӨР



Жил бүрийн 3 дугаар сарын 24-ний өдрийг Дэлхийн Сүрьеэтэй тэмцэх өдөр болгосон. Сүрьеэтэй тэмцэх энэ өдрийг **“Жил бүр дэлхий дээр сүрьеэгээр 9 сая хүн өвддөг ч тэдний 3 сая нь эмнэлгийн тусламж авч чаддаггүй. Сүрьеэгээр өвдсөн хүн бүрийг илрүүлж, эмчилгээнд хамруулж, эдгэрүүлцгээе”** гэсэн уриатайгаар тэмдэглэдэг байна.

Эрт илрүүлж эмчлэх нь сүрьеэгийн тархалтаас сэргийлэх гол арга юм. Шинж тэмдгүүдийг мэдэж аль болох эрт эмчид үзүүлж шинжилгээ заавал хийлгээрэй.

СҮРЬЕЭ ЭМЧЛЭГДДЭГ ӨВЧИН